



Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 9 тоот Хавсралт 2

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧТАЙ ХАРИЛЦАХ ХӨТӨЛБӨР

НЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Худалдаа, хөгжлийн банк (цаашид **“Банк”** гэх)-ны хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр (цаашид **“хөтөлбөр”** гэх)-ийн зорилго нь Компанийн засаглалын кодекс¹-ын 9 дүгээр зарчмын 9.2 дахь хэсэгт заасныг удирдлага болгон хөрөнгө оруулагчдын оролцоог Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, эрх бүхий зохицуулах байгууллагын дүрэм, журам, зааврын дагуу эрх тэгш хангах, тэдгээртэй харилцах, мэдээллийг цахим сувгаар солилцохтой холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Хөтөлбөрийн оролцогч талууд нь Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид **“ТУЗ”** гэх), гүйцэтгэх удирдлага, Банкны эрх бүхий албан тушаалтан², хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид байна.
- 1.3. Хөтөлбөрийг оролцогч талууд хууль дээдлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хүндэтгэх, хамгаалах, хувьцаа эзэмшигчдэд эрх тэгш хандах, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор хангах зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

- 2.1. Хөтөлбөр нь дараах зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна. Үүнд:
 - 2.1.1. Банк болон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хоорондын итгэлцэл болон оролцоог нэмэгдүүлэх, санал хүсэлтийг хүлээн авах, хариу өгөх;
 - 2.1.2. Банкны хөрөнгө оруулагчдыг таньж мэдэх, цаашлаад учирч болох эрсдэлээс хамгаалах зорилгоор тухай бүр хууль, тогтоомжид заасан шаардлагыг биелүүлж ажиллах;
 - 2.1.3. Банкны хувьцааны ханшийг бодитой үнэлэх боломжоор хөрөнгө оруулагчдыг хангахын тулд Банкны бизнес, засаглал, санхүүгийн үзүүлэлтүүд, шаардлагатай тайлан, мэдээ, хэтийн төлөвийн талаарх мэдээллийг Арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан хөрөнгө оруулагчдад хүргэх;
 - 2.1.4. Техник, технологи, цахим суваг ашиглан түргэн шуурхай, ойлгомжтой, хялбар байдлаар хөрөнгө оруулагчтай харилцах, харилцан мэдээлэл солилцох;
 - 2.1.5. Банкны хувьцаа арилжаалагдаж буй хөрөнгийн бирж болон эрх бүхий зохицуулах байгууллагаас баталсан журмын дагуу холбогдох мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд бичгээр хүргүүлэх, Банкны веб сайт болон арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан нийтэд мэдээлэх.
- 2.2. Хөтөлбөрийн 2.1 дэх хэсэгт заасан зорилгын хүрээнд дараах зорилтыг тавьж ажиллана. Үүнд:
 - 2.2.1. Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд ойлгомжтой, хялбар байдлаар холбогдох мэдээллийг хүргэх, харилцах мэдээллийн сувгийг тодорхойлох, хөгжүүлэх;

¹ Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан.

² “Эрх бүхий албан тушаалтан” гэдэгт Банкны төлөөлөн удирдах зөвлөл (цаашид **“ТУЗ”** гэх), Банкны албан ёсны шийдвэрийг гаргах, гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцогч албан тушаалтан, Банкны дүрэмд Эрх бүхий албан тушаалтан гэж тодорхойлсон этгээдүүд болон хариуцан гүйцэтгэж буй ажил үүрэг, үйл ажиллагааны чиглэлийн дагуу гүйцэтгэх захирлын тушаалаар эрх бүхий этгээдээр тогтоогдсон этгээдүүдийг ойлгоно.

- 2.2.2. Банкны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бодитой мэдээлэх;
- 2.2.3. Банкны санхүүгийн бус мэдээллийг хөрөнгө оруулагчид олж авах нөхцөлийг бүрдүүлэх;
- 2.2.4. Банкны хувьцаа арилжаалагдаж буй хөрөнгийн бирж болон эрх бүхий зохицуулах байгууллагаас тавьж буй шаардлагыг биелүүлэх;
- 2.2.5. Банкны удирдлага болох ТУЗ, гүйцэтгэх удирдлагад хөрөнгө оруулагчдын санал хүсэлтийг тогтмол танилцуулж ажиллана.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АРГА ХЭМЖЭЭ

- 3.1. Хөтөлбөрийн хүрээнд оролцогч талуудад хууль тогтоомж, дүрэм, журамд заасан шаардлагатай мэдээллийг хүргэх, тэдгээрийн санал хүсэлтийг хүлээн авах, харилцан мэдээлэл солилцох болон бусад асуудлаар Банкнаас хөрөнгө оруулагчидтай харилцахдаа дараах сувгийг ашиглана. Үүнд:
 - 3.1.1. Банкны цахим суваг;
 - 3.1.2. Банкны хөрөнгө оруулагчтай харилцах алба нь ТУЗ-ийн дэргэдэх Ажлын алба (цаашид “ТУЗДАА” гэх);
 - 3.1.3. Зохицуулагч байгууллагын цахим суваг;
 - 3.1.4. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын цахим суваг;
 - 3.1.5. Банктай холбогдох бусад харилцааны суваг;
 - 3.1.6. Компанийн тухай хуулийн 60.4-т зааснаас бусад шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн шийдвэрээр хэвлэл, мэдээллийн хэрэгсэл ашиглан мэдээлэл хүргэж болно.
- 3.2. Хөтөлбөрийн хүрээнд дараах үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд ажиллана. Үүнд:
 - 3.2.1. Хөрөнгө оруулагчдын санал хүсэлтийг хүлээн авч, холбогдох ажлыг хэрэгжүүлэх;
 - 3.2.2. Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн зөв, бүрэн бүтэн, тэнцвэртэй байдлыг хангах арга хэмжээ авах;
 - 3.2.3. Олон улсын болон жишиг хөтөлбөр, төслийг Банкны дотоод зохион байгуулалт, бүтэц, боломжийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тухай бүр авах.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 4.1. Хөтөлбөрийг Банкны ТУЗ нь өөрийн эрх мэдлийн хүрээнд нийцүүлэн баталж, холбогдох үйл ажиллагааны чиглэлийн дагуу арга хэмжээний хэрэгжилтэд ерөнхий хяналт тавьж ажиллана.
- 4.2. Тус хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг хариуцах алба нь ТУЗДАА байх ба шаардлагатай тохиолдолд хөрөнгө оруулагч нартай харилцах зохион байгуулалтын тухайлсан нэгжийг шинээр байгуулж болно.
- 4.3. ТУЗДАА нь дараах эрх, үүрэгтэй ажиллана. Үүнд:
 - 4.3.1. Банкийг хөрөнгө оруулагчдад төлөөлөх ажлыг хийж гүйцэтгэх;
 - 4.3.2. Банканд ирж буй мэдээллийг хянаж шалган, дотооддоо хуваарилах;
 - 4.3.3. Хөрөнгө оруулагчдын хүсэж буй мэдээлэлд дүн шинжилгээ хийж, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагад танилцуулах.
- 4.4. ТУЗДАА нь хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих арга хэмжээг зохион байгуулахыг Гүйцэтгэх удирдлагад үүрэг болгож болох ба Гүйцэтгэх удирдлага зохион байгуулсан арга хэмжээний тайланг ТУЗДАА-д тайлагнана.

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ТАЙЛАГНАЛ, ҮНЭЛГЭЭ, ҮР ДҮН

- 5.1. Хөтөлбөрт заасан зорилго ханган ажилласан эсэх, зорилтод хүрсэн эсэх, хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн арга хэмжээнүүдийг хийж гүйцэтгэсэн байдлаар үр дүнг тодорхойлно.
- 5.2. Хөтөлбөрийн тайлан, үр дүнгийн мэдээлэл, үнэлэлт, дүгнэлтийг Банкны цахим хуудас болон болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсанд байршуулж болно.
- 5.3. Хөтөлбөрийн тайланг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх ажлыг ТУЗДАА хариуцна.